



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/А96

Булган сум

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн  
үед авах арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 373 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Томуу, томуу төст өвчний дэгдэлт буурч аймгийн хэмжээнд алаг цоог дэгдэлтийн үед шилжсэн тул 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд холбогдох зааврын дагуу арга хэмжээ авч ажилласугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/748 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгавар, Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан даалгавруудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг төрийн байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

